

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт 2
ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 3
Захирал: Д.Ганбилэг	Бүлэг 1: Сонгон шалгаруулалт сайжирч байгаа ч боловсронгуй болгох шаардлага байна
Аудитын менежер: Х.Баярмаа	Сонгон шалгаруулалтын үр дүнд зарим ахиц гарч байна..... 4
Ахлах аудитор: Г.Цэдэнбалжир	Шалгалт зохион байгуулах зардлыг санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтгүй байна 7
Аудитор: З.Ариунзаяа	Хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай 9
Шинжээч: Л.Эрдэнэчулуун Ц.Эрдэнэчулуун	ТАЗ, ҮСХ, Сангийн яамнаас гаргасан төрийн албан хаагчдын тоо хоорондоо уялдахгүй байна 9
2010 оны 12 дугаар сар	Бүлэг 2: Зарим яам, агентлаг хууль тогтоомж зөрчин томилгоо хийж байна
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.mnao.mn	Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэр, санал дүгнэлтийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна 11
Е-тэйл хаяг: mnao@mnao.mn	Зарим ТАЗСЗ хууль, журам биелүүлэхгүй байна 12
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	Зарим сонгон шалгаруулалтад өрсөлдөөний зарчим алдагдсан байна 13
ХАЯГ: Үндэсний аудитын газар 210642 Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс	Төрийн албаны тухай шинэчилсэн хуульд заасан журам бүрэн батлагдаагүй байна 14
	Удирдах ажилтны нөөцийг мэдээлэхгүй байна 15
	Ихэнх гомдол, маргаан ажлаас үндэслэлгүй халагдсан, албан тушаалтны хууль бус ажиллагаатай холбоотой байна 15
	ТАЗСЗ-ийн үйл ажиллагааг 2009 оноос эхлэн дүгнэж байна 15
	Дүгнэлт 16
	Зөвлөмж 17
	Холбогдох байгууллагын санал:
	Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн санал 18
	<u>ХАВСРАЛТУУД:</u>
	Хавсралт №1 19
	Хавсралт №2 20
	Хавсралт №3 21
	Хавсралт №3.1 22
	Хавсралт №4 23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АБТ	<i>Ажлын байрны тодорхойлолт</i>
АНАГ	<i>Аймаг, нийслэлийн аудитын газар</i>
БОАЖ	<i>Байгаль орчин, аялал жуулчлал</i>
БСШУ	<i>Боловсрол, соёл, шинжлэх ухаан</i>
ЗГТХ	<i>Засгийн газрын тухай хууль</i>
ЗГХА	<i>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг</i>
ЗГХЭГ	<i>Засгийн газрын хэрэг эрхлэх газар</i>
ЗДТГ	<i>Засаг даргын Тамгын газар</i>
ЗТБХБ	<i>Зам тээвэр, барилга, хот байгуулалт</i>
ИТХТ	<i>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид</i>
НББ	<i>Нягтлан бодох бүртгэл</i>
НБД	<i>Нарийн бичгийн дарга</i>
НХХ	<i>Нийгмийн хамгаалал, хөдөлмөр</i>
ТАЗ	<i>Төрийн албаны зөвлөл</i>
ТАЗСЗ	<i>Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл</i>
ТАТХ	<i>Төрийн албаны тухай хууль</i>
ТАХ	<i>Төрийн албан хаагч</i>
ТБУСТХ	<i>Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль</i>
ТЕГ	<i>Татварын ерөнхий газар</i>
ТНБД	<i>Төрийн нарийн бичгийн дарга</i>
ТӨХ	<i>Төрийн өмчийн хороо</i>
УИХ	<i>Улсын Их Хурал</i>
УНДЕГ	<i>Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар</i>
ҮСХ	<i>Үндэсний статистикийн хороо</i>
ҮАГ	<i>Үндэсний аудитын газар</i>
ЭБЭХ	<i>Эрдэс баялаг, эрчим хүч</i>
ЭМЯ	<i>Эрүүл мэндийн яам</i>

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хорооны санал, Үндэсний аудитын газрын 2010 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалт, түүний үр дүнг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Хамарсан хүрээ

Аудитад Төрийн албаны төв байгууллагын 2008, 2009 онд зохион байгуулсан төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалт, түүнтэй холбогдох зарим байгууллага, нэгжийг хамруулав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн 2008, 2009 оны тайланг судлах,
- Төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй Төрийн албаны зөвлөлийн холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, судалгаа, тоон мэдээлэл авах,
- Сонгон шалгаруулалттай холбогдсон төсөв, санхүүгийн нөөц бүрдүүлэлт, түүний зарцуулалтыг үндсэн баримттай тулгах,
- Зарим яам, агентлаг, аймгийн ЗДТГ-ын дэргэдэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, салбар зөвлөлийн гишүүд, аймгийн ерөнхий аудитор нараас санал асуулга авах,
- Төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах явц болон бүртгэл, шалгалт авах, үр дүнг мэдээлэх хүртэлх үйл ажиллагааны явцад хөндлөнгийн ажиглалт, зураг авалт хийх.
- Цуглуулсан баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх,

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1: Сонгон шалгаруулалт сайжирч байгаа ч боловсронгуй болгох шаардлага байна

Оршил



1.1 2002 онд батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн дүрэм”-ийг УИХ-ын 2009 оны 87 дугаар тогтоолоор “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм” болгон шинэчилжээ.

1.2 ТАЗ УИХ-ын 2002 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу удирдах албан тушаалд томилогдох ажилтныг нээлттэй өрсөлдөөний зарчмыг баримтлан сонгон шалгаруулж дүгнэлт гарган холбогдох байгуулагад хүргүүлж байна.

1.3 ТАЗ-өөс 2004 онд баталсан “Төрийн албаны мэргэшлийн шалгалт авах болзол, журам”-ыг 2009 оны 63 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам” болгон шинэчилсэн бөгөөд төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг ТАЗ болон ТАЗСЗ¹ зохион байгуулж байна.

1.4 Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулж томилох, мөн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан үед төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийг өрсөлдүүлэн мэргэшлийн шалгалт авах үйл ажиллагааны явцыг хураангуйлсан зураглалыг хавсралт ¹¹, ¹²-т үзүүлэв.

1.5 ТАЗ болон ТАЗСЗ-өөс сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх төрийн жинхэнэ албанд шууд хамаарч байгаа албан тушаалын одоогийн ангилал, зэрэглэлийг хавсралт ¹³-т үзүүлэв.

Сонгон шалгаруулалтын үр дүнд зарим ахиц гарч байна

1.6 ТАТХ-д төрийн албаны удирдах албан тушаалтанд тавих ерөнхий шаардлагад заасан “ур чадвар”, “мэргэшсэн”² гэдэг шалгуурыг илүү оновчтой, дэлгэрэнгүй тодорхойлох нь зүйтэй байна.

1.7 ТАЗ-өөс удирдан зохион байгуулсан төрийн албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг сүүлийн 6 жилээр үзүүлбэл:

1. Албан тушаал дэвшүүлэх журмаар

/Хүнээр/

Үзүүлэлт	2004	2005	2006	2007	2008	2009
АО-оос нэр дэвшүүлсэн хүний тоо*	75	113	47	76	82	79
ТАЗ-ийн дүгнэлт гарсан хүний тоо*	55	108	47	76	82	74

¹ ТАТХ-ийн 34.13, “Зөвлөл нь орон тооны болон орон тооны бус салбар зөвлөл, ажлын албатай байна.

² *Ojitooite*: ОАО-өөс 10.1. “Төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай, мэргэшсэн байх явдал мөн.”

Томилогдсон хүний тоо*	24	44	17	29	42	73
------------------------	----	----	----	----	----	----

2. Нээлттэй өрсөлдөөний зарчмаар

/Хүнээр/

Үзүүлэлт	2004	2005	2006	2007	2008	2009
Нэр дэвшүүлсэн хүний тоо*	10	200	64	27	65	39
ТАЗ-өөс дүгнэлт гарсан хүний тоо*	10	182	59	27	65	228
ТАЗ-өөс санал болгосон*	10	150	57	27	65	39
Албан тушаалд томилогдсон*	2	43	15	8	18	36
Албан тушаалын тоо	2	45	15	9	18	39
1 албан тушаалд өрсөлдсөн тоо	5	3	4	3	3	1

*Эх сурвалж: Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний 2009 оны тайлан

Ажлын байр/албан тушаал/-ны тоо	24	27	14	24	42	73
---------------------------------	----	----	----	----	----	----

1.8 Хүснэгтээс үзэхэд ТАЗ-өөс дүгнэлт гаргаж нэр дэвшүүлсэн хүмүүсээс 2005 онд 17, 2006 онд 3, 2007 онд 5 хүнийг эрх бүхий албан тушаалтан томилоогүй байсан бол 2008, 2009 онд нэр дэвшүүлсэн хүмүүс тухайн албан тушаалд томилогдсон байна.

1.9 Нээлттэй өрсөлдөөний зарчмаар 2008 онд явуулсан сонгон шалгаруулалтаар нэр дэвшсэн иргэд тухайн албан тушаалд бүрэн томилогджээ. Харин 2009 онд 36 сул ажлын байр зарлагдсан бөгөөд 3 албан тушаалын томилгоог эрх бүхий албан тушаалтан ТАЗ-ийн дүгнэлтгүйгээр томилсон байна.

1.10 “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ыг зөрчиж, 2009 онд Засгийн газрын зарим агентлаг, нутгийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас 16 удирдах ажилтанг томилсон байсныг ТАЗ-өөс эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэн хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээг авчээ.

1.11 Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлсэн байдлын судалгаанд ТАЗСЗ-ийн мэдээ хамрагдахгүй байна.

1.12 ТАЗ-өөс төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын дүнг сүүлийн 6 жилийн байдлаар үзүүлбэл:

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНД АНХ ОРОХ МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТ							/Хүнээр/
Д.д	Үзүүлэлт	2004	2005	2006	2007	2008	2009
1	Зарласан ажлын байрны тоо*	640	970	1,968	927	2,045	4,862
2	Шалгалт өгсөн хүний тоо*	3,047	4,024	4,719	3,601	8,133	25,450
3	Шалгалтанд тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн хүний тоо*	1,309	1,829	1,968	847	2,444	12,241
	Эзлэх хувь*	43.0	45.5	41.7	23.5	30.1	48.1
4	Нөөцөд бүртгэгдсэнээс ажилд орсон хүний тоо*	752	970	1,180	300	920	4,723
	Эзлэх хувь*	57.4	53.0	60.0	35.4	37.6	38.6
5	Авсан шалгалтын тоо	1	1	1	2	7	7
6	Оролцогчдын тоог ажлын байрны тоонд харьцуулснаар	5	4	2	4	4	5

*Эх сурвалж: Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний 2009 оны тайлан

1.13 2008 онд төрийн жинхэнэ албаны сул чөлөөтэй 2045 ажлын байрны төлөө 8380 хүн бүртгүүлж, шалгалтад 8133 хүн оролцсоноос 30.1 хувь буюу 2444 хүн тэнцэж, 920 хүн ажилтай болжээ. Үүнээс төрийн захиргааны төв болон Засгийн газрын харъяа агентлагийн захиалсан 280 сул ажлын байранд 2098 хүн бүртгүүлж, 2050 хүн шалгалтад хамрагдаж 18.9 хувь буюу 389 хүн тэнцсэн байна.

1.14 2009 онд зарлагдсан нийт 4862 ажлын байрыг нөхөх мэргэшлийн шалгалтад 26242 хүн бүртгүүлж 25450 хүн шалгалт өгснөөс 48.1 хувь буюу 12241 хүн тэнцэж, 4723 хүн ажлын байраар хангагджээ.



1.15 Төрийн жинхэнэ албанд анх орох шалгалтыг 2007 онд 3601, 2008 онд 8133 хүн өгч байсан бол 2009 онд 25450 болж, өмнөх онуудаас бараг 2 дахин өссөн байна. Мөн 2009 онд 12241 хүн шалгалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн нь өмнөх 5 жилийн дүнгээс 3844-өөр илүү байна.

1.16 ТАЗ-өөс 2008 онд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас ажлын байрны захиалгыг авч нэгтгэн, “Зууны мэдээ” сонинд зарлан мэдээлдэг байсан бол өнгөрсөн оноос ТАЗ-ийн цахим хуудсаар дагнан мэдээлдэг болжээ.

1.17 2008 онд Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан шалгалтыг ТАЗ-ийн мэргэшлийн шалгалтын комисс хангалтгүй бэлтгэж, стандартын шаардлага хангахгүй шалгалтын хуудас ашигласнаас 2000 гаруй хүний шалгалтын материалыг гараар засахад хүрч, улмаар тухайн шалгалттай холбоотой шүүмжлэл, гомдол 200 гаруй гарч байжээ.

1.18 Удирдлагын академи “Төрийн албаны мэргэшлийн шалгалтад зориулав” сорилын номыг хэвлэн, ширхгийг нь 7000 төгрөгөөр худалдаж, шалгалтад зориулсан төлбөртэй сургалт явуулан, сорилын хариуг хэвлэн худалдсан байна.

ЗГХА Жижиг, дунд үйлдвэрийн газрын 1, Эрүүл мэндийн газрын 6 ажлын байранд 2010 оны 10 дугаар сард авсан шалгалтын үйл ажиллагаанд дараахь зүйл ажиглагдав. Үүнд:

- Бүртгэлийн үйл ажиллагаанд анх удаа ажил олгогч байгууллагын төлөөлөл оролцсон.
- Албан тушаалын ангилал өөр байхад сорил, ур чадварын шалгалтын агуулга ижил байсан.
- Оролцогсдын идэвхи сул, хоцорч ирсэн, шалгалтын картанд шифр, сорилын бүлэг, бусад тэмдэглэгээг алдаатай бөглөснөөс машинд дүнг гаргахад алдаа гарсан.
- Ярилцлагын асуултын сонголт, өрнөлт, тавьж буй үнэлгээг цаашид анхаарах шаардлагатай
- ЖДҮГ-ын 1 ажлын байранд 5 хүн тэнцсэн ч тухайн албан тушаалд очилгүй татгалзсан.
- Сонгон шалгаруулах өнөөгийн тогтолцооны талаар шалгалт өгсөн 28 хүнээс санал авахад ажил олгогч шалгаруулалт явуулахыг 8 хүн, одоогийн тогтолцоог 20 хүн дэмжиж байв.

1.19 Сонгон шалгаруулалтыг боловсронгуй болгох талаар анхаарвал зохих зарим асуудал ч байна.

2009 оноос өмнөх байдал	Одоогийн байдал	Анхаарах Асуудал
Мэргэшлийн шалгалтыг жилд 1-2 удаа зохион байгуулж байсан.	2009 оны сүүлийн хагасаас эхлэн сул орон тоо гарсан тухай бүрт сонгон шалгаруулалтыг зарлаж явуулдаг болсон.	Ажил олгогчоос сул орон тоог зарлахгүй байх тохиолдол гарч байна.
Сонгон шалгаруулалтыг гараар бүртгэж,	Сонгон шалгаруулалтын бүртгэлийг цахим хэлбэрээр	Цахим бүртгэлээр хуурамч баримт

дараалал үүсгэж, иргэдийг олон цагаар чирэгдүүлдэг байжээ.	бүртгээдэг болсон.	материалыг үндэслэн бүртгүүлэх магадлалтай.
Сонгон шалгаруулалтаар 3 хүний нэрийг дэвшүүлж, ерөнхий менежер сонгон томилдог байсан.	Сонгон шалгаруулалтаар 1-ээр гарсан хүний нэрийг дэвшүүлж, томилуулдаг болсон.	Тодорхой шалтгаангүйгээр нэр дэвшигчийг томилохгүй байх.
Сонгон шалгаруулалтын сорилыг хувь хүн гараар боловсруулж шалгадаг байснаас гомдол, маргаан их гардаг байсан.	Сонгон шалгаруулах сорилын гарын авлага гаргаж хэвлүүлж нийтэд худалдсан. Шалгалтын сорилыг мэдээллийн сангаас сэлгэх програмаар боловсруулж, үр дүнг уншуулж байгаа тул маргаан гарах нь багассан.	Сорил болон ур чадварын шалгалтын агуулга сул гарсан албан тушаалын ангилал, зэрэглэлээс хамааралгүй боловсруулагддаг.
Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгээгдсэн тохиолдолд ажлын байрны ангилал зэрэглэл харгалзахгүй албан тушаалд томилогддог байсан.	Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгээгдсэн тохиолдолд тухайн ажлын байрны ангилал, зэрэглэлээс өөр ангилал, зэрэглэл шилжихэд хязгаарлалт тогтоосон.	Хязгаарлалтыг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.
ТАЗ-ийн 2004 оны 36 дугаар тогтоолоор баталсан Мэргэшлийн шалгалтаар <ul style="list-style-type: none"> ▪ Төрийн бодлого, төрийн албатай холбогдсон хууль эрх зүйн мэдлэгийн сорилын, ▪ Ярилцлагын шалгалт авдаг байсан. 	ТАЗ-ийн 2009 оны 63-р тогтоолоор Мэргэшлийн шалгалтыг <ul style="list-style-type: none"> ▪ Төрийн бодлого, төрийн албатай холбогдсон хууль эрх зүйн мэдлэгийн сорилын, ▪ Баримт бичгийн, ▪ Ур чадварын, ▪ Ярилцлагын шалгалт авдаг болгон нарийвчилсан. 	Ярилцлагын шалгалтад асуулт хариултаар оноо өгч, комиссын гишүүдийн өгсөн онооны дунджаар дүгнэж байна. Баримт бичиг боловсруулах ур чадварыг харгалзан үздэггүй байна.
Сонгон шалгаруулалтад тэнцсэн бүх хүн эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, чирэгдэл ихтэй байсан.	Сонгон шалгаруулалтаар 1-ээр гарсан хүнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах болсон.	
Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулах ажиллагаанд ТАЗ-ийн 2004 оны хурлаар сайшаагдсан зөвлөмжийг ашиглаж байна.	Сонгон шалгаруулах ажиллагаанд боловсрол мэдлэг, ажлын туршлага, гадаад хэл, компьютерийн мэдлэгээр нэмэлт оноо өгдөг болсон.	Үнэлгээ өгөх арга зүйг албан ёсоор зохицуулаагүй зөвлөмж, албан ёсоор баталгаажаагүй практик гээдэх аргачлалыг мөрдөж байна.

Шалгалт зохион байгуулах зардлыг санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтгүй байна

1.20 ТАЗ-ийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-д мэргэшлийн шалгалттай холбоотойгоор гарах зардлыг шалгалт өгөгч өөрөө хариуцах талаар тусгажээ.³

1.21 Сонгон шалгаруулалт зохион байгуулах зардал ТАЗ-ийн төсөвт тусгагддаггүйгээс авч байгаа хураамж, түүнийг хэрхэн зарцуулах талаар эрх зүйн зохицуулалтгүй байна.

1.22 ТАЗ-ийн 2009 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хурлын тэмдэглэлд мэргэшлийн шалгалтын зардлыг олох зорилгоор шалгалтад оролцогчдоос хотод 10000 төгрөг, хөдөөд 5000 төгрөг гаргуулах санал хэлэлцэгдсэн боловч шийдвэрлэсэн хэсэгт зардлын дүн, тоо хэмжээг албан ёсоор баталгаажуулаагүй байна.

1.23 ТАЗ 2009 онд төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтыг зохион байгуулахаар Удирдлагын академитай гэрээ байгуулж, тус академийн тамга тэмдгийг ашиглан Худалдаа хөгжлийн болон Голомт банкинд данс нээж, шалгалтын зардлын хураамжийг төвлөрүүлэн зарцуулжээ.

1.24 Уг 2 банкны дансанд 2009 оны 5 дугаар сараас өнөөдрийг хүртэлх хугацаанд шалгалтын хураамжид 26.5 сая төгрөг, Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын гарын авлага номны үнэ 49.7 сая төгрөг, бүгд 76.2 сая төгрөг, ТАЗ-ийн тайлан тэнцлээс гадуурх касст 16.5 сая төгрөг, нийт 92.7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, дараахь зардалд зарцуулжээ. Үүнд:

- Багш, ажилтан нарын ажлын хөлсөнд 20.1 сая төгрөг,
- Унаа, хоолны зардалд 3.6 сая төгрөг,
- Ном хэвлүүлэх зардалд 27.6 сая төгрөг,
- Томилолтын зардалд 7.8 сая төгрөг,
- Түрээсээр ашиглаж байгаа байрны мэргэшлийн шалгалт авах танхимыг тохижуулах, засварын ажлын зардалд 13.0 сая төгрөг,
- Онлайн бүртгэлийн үйлчилгээ, сэлгээний програмын үнэнд 8.4 сая төгрөг,
- Бусад зардалд 12.0 сая төгрөг, бүгд 92.7 сая төгрөгийг зарцуулжээ.

Сонгон шалгаруулалтын үр дүн, дутагдал, одоогийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх, түүнийг хэрхэн боловсронгуй болгох зэрэг асуудлаар 18 аймгийн ТАЗСЗ-ийн гишүүдээс санал авахад:

- Аймгийн ТАЗСЗ-ийн дарга аймгийн ЗДТГ-ын дарга байх нь хараат бус байдалд нөлөөлөх,
- Удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулахдаа мэдлэг, дадлага, туршлагатай хүнийг албан тушаал дэвшүүлэх замаар ажиллуулдаггүй,
- ТАХ-ийн ёс зүйн хэм хэмжээ, хууль тогтоомж зөрчсөн этгээдтэй хариуцлага тооцдоггүй,
- Шалгалтад тэнцээд ажлын байрандаа очдоггүй,
- Нөөцөд бүртгүүлэхийн тулд шалгалтад ордог,
- Шалгалтад эхний байранд орж санал болгосон хүнийг нэр дэвшүүлдэг ч томилдоггүй,
- ТАХ-ийн ажлын байранд тавигдах шалгуурыг нэгдсэн журмаар зохицуулаагүйгээс тухайн хүнд тохируулан тогтоодог,
- Нэг хүний нэрийг дэвшүүлснээс ажил олгогчийг сонголтгүй болгож, улмаар дадлага туршлагагүй хүн томилогдох эрсдэл гардаг гэх мэт санал шүүмжлэл ирүүлжээ.

1.25 Дээрх орлого, зарлагын гүйлгээг ТАЗ болон Удирдлагын академийн тайлан тэнцэлд тусгаагүй бөгөөд энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1, 7.4, 8.3 дахь заалтыг⁴ тус тус зөрчсөн байна.

³ Журмын 3.25 дахь хэсэгт: “Мэргэшлийн шалгалттай холбоотойгоор гарах зардлаа нэр дэвшигч өөрөө хариуцна”, “Мэргэшлийн шалгалтад анх орохыг хүссэн иргэнийг бүртгэх” хэсгийн 36.7-д “Шалгалтын зардал төлсөн баримт”.

⁴ 7.1-еэ “Айдай шади аадеидоо иу йүадеаи аиаид ац доаюе доеод, һайд цц аеэи оаеэаи, йуууеэеэа цйи ц’а аадаао цйуһеуе аиһи”, 7.4-еэ “Аа адбөи йүаа, ааеадооеаауи баедаеааа, йүадеаи аиаиа+ иу цееааюеуе, цее+еааууиее шао ааиэеааа, аа адбөи цее ааеэеааааиу дц дүүйи аадһаи до’аи°, үб цц һаюдееи до’ае°, оод+е’еод ац дееа аидай шади аадеидооа ае+еод бөеа ац да ццйу”,

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ОРОН ТООНЫ НӨХӨН ХАНГАЛТ⁸.

Үзүүлэлт			2004	2005	2006	2007	2008	2009
Төрийн албан хаагчийн орон тоо*			124,922	124,964	126,439	143,505	150,695	154,803
Төсөвт байгууллагад ажиллагсад**			122,308	137,135	140,268	144,192	149,752	175,507
Үүнээс:	Нөхөгдөөгүй орон тоо	/хувиар/	2.1	(9.7)	(10.9)	(0.5)	0.6	(13.4)
		/тоогоор/	(2,614)	12,171	13,830	687	(943)	20,704
Төрийн албан хаагчийн орон тоо***			121,760	120,581	128,088	140,258	144,049	148,223
Үүнээс:	Төрийн захиргааны албан хаагч:		9,284	9,463	9,940	10,503	13,104	14,420
	Тэргүүн түшмэл		130	72	83	91	89	94
	Эрхэлсэн түшмэл		314	288	336	346	410	417
	Ахлах түшмэл		1,659	1,626	1,628	1,729	1,520	1,688
	Дэс түшмэл		5,001	5,216	6,761	6,005	8,383	9,314
	Туслах түшмэл		2,180	2,261	1,091	2,332	2,702	2,907

Эх сурвалж, Үүнээс: Сангийн яам*, Үндэсний статистикийн хороо**, Төрийн албаны зөвлөл***

1.31 Хүснэгтээс үзэхэд дээрх 3 байгууллагаас гаргаж байгаа төрийн албан хаагчдын орон тооны талаархи мэдээлэл хоорондоо зөрүүтэй байна. Тухайлбал, 2009 онд ТАЗ-өөс гаргасан төрийн албан хаагчийн тооноос Сангийн яам 6580 хүнээр, ҮСХ 27284 хүнээр тус тус илүү байна.

1.32 Төрийн албан хаагчийн орон тооны мэдээллийг Сангийн яам улсын төсөвт батлагдсан орон тоогоор, ҮСХ хүн амын ажил эрхлэлтийн мэдээ буюу төсөвт байгууллагад ажиллагсдын тоогоор, ТАЗ нь төсөвт байгууллагуудаас авдаг төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний жилийн эцсийн тайланг үндэслэн нэгтгэн тайлагнаж байна.

1.33 Төрийн албан хаагчийн тоог нэг аргачлалаар боловсруулж гаргадаггүйгээс дээрх гурван байгууллагын мэдээлэл өөр өөр байна.

⁸ Өндөр ачаагаар дамжуулан, төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалт, түүний үр дүн

Бүлэг 2: Зарим яам, агентлаг хууль тогтоомж зөрчин томилгоо хийж байна

Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэр, санал дүгнэлтийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна

2.1 ТАЗ-өөс сонгон шалгаруулсан хүнийг удирдах албан тушаалд томилохгүй тохиолдол гарч байна. Тухайлбал:

- 2009 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 4 дүгээр хурлын тэмдэглэлээр ЗГХА Соёл, урлагийн хорооны даргын албан тушаалд 7 хүн бүртгүүлснээс 6 нь сонгон шалгаруулалтад орж Н.Батмөнх 74.1 оноо авчээ. Харин Б.Лхагвасүрэнг төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үндэслэлээр сонгон шалгаруулалтад оруулаагүй байна. Гэтэл уг албан тушаалд Засгийн газрын шийдвэрээр Б.Лхагвасүрэн томилогдон ажиллаж байна.

2.2 ТАЗ иргэдийн гомдлыг шалган шийдвэрлэхдээ хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцох талаар хангалтгүй ажилласан байна. Тухайлбал:

- ТАЗ-өөс УНДЕГ-т хийсэн шалгалтаар УНДЕГ-ын дарга Ч.Алтанхуяг 2009 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 31 дүгээр тушаалаар бүтцийн өөрчлөлт хийж 20 гаруй хүнийг ажлаас халсан атал сонгон шалгаруулалтад ороогүй мөн тооны хүнийг ажилд авсан болохыг тогтоожээ. ТАЗ-ийн 2009 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 90 дүгээр тогтоолд ТАТХ-ийн 4.2.5, 19.2, 22.1, 27.2.1-27.2.4, ТБУСТХ-ийн 5.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 35.1.2, 35.1.3 заалтуудыг зөрчсөн “Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2009 оны 31 дүгээр тушаалыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй” гэжээ. Тус газраас ажлаас чөлөөлөгдсөн 17 хүнд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нийт 40.2 сая төгрөгийн тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас олгожээ. Хууль бус шийдвэр гаргаж нийгмийн даатгалын санд хохирол учруулсан хүмүүст арга хэмжээ авахуулах талаар ТАЗ-өөс холбогдох байгууллагад хандаагүй байна.

2.3. Мэргэшлийн шалгалтад тэнцэж, нэр дэвшсэн хүмүүсийг томилохгүй байх, эсвэл тэд өөрсдөө татгалзах явдал гарч байна. Тухайлбал:

- 2009 онд Төрийн захиргааны төв байгууллагын 50 ажлын байранд 46 иргэнийг санал болгож, үүнээс 35 иргэн томилогдож, 11 хүн өөрийн хүсэлтээр татгалзсан байна.
- Засгийн газрын 22 агентлагийн 121 сул ажлын байранд 70 иргэнийг нэр дэвшүүлснээс 55 хүн томилогдож, өөрийн хүсэлтээр 14 хүн татгалзаж, 1 хүн томилогдоогүй байна.
- УИХ-ын харъяа 5 байгууллагын 42 ажлын байранд 40 иргэнийг нэр дэвшүүлснээс УИХ-ын Тамгын газарт 3 иргэнийг томилоогүй байна.
- Нутгийн захиргааны байгууллагын нэр дээр 1588 ажлын байранд 919 иргэнийг нэр дэвшүүлснээс 731 иргэнийг томилсон бөгөөд өөрийн хүсэлтээр 139 татгалзаж, 19

иргэн томилогдоогүй байна.

2.4. 2010 оны 8 дугаар сар хүртэл 400 сул орон тоо зарлагдан нийт 6 удаа зохион байгуулсан шалгалтад 2877 иргэн бүртгүүлж, 2795 иргэн шалгалт өгснөөс 68.9 хувь буюу 1925 иргэн тэнцсэн байна. Тэнцсэн иргэдээс онооны дарааллаар жагсааж 329 хүнийг нэр дэвшүүлэхэд 206 хүн томилогдож, 97 хүн өөрийн хүсэлтээр татгалзаж, 25 ажлын байранд нэр дэвшигчдийг томилоогүй байна. Үүнд:

- БСШУЯ-ны Ерөнхий боловсролын сурах бичгийн болон сургалтын орчны бодлого, Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын зээл, тусламжийн бодлого зохицуулалтын мэргэжилтний орон тоонд нэр дэвшсэн 2 хүнийг томилоогүй бөгөөд шалтгааныг ТАЗ-д тайлбарлаагүй байна.
- ЭБЭХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын мэргэжилтнээр нэр дэвшсэн хүнийг тодорхойгүй шалтгаанаар томилоогүй байна.
- ЗГХА Усны газрын Удирдлага, санхүүгийн хэлтсийн байгууллага, албан хэрэг хөтлөлт, хүний нөөцийн асуудал хариуцсан ажлын байранд нэр дэвшигчийг томилоогүй байна.
- Нутгийн захиргааны байгууллагад 21 албан тушаалын томилгоо хийгдээгүй байна.

2.5 Сонгон шалгаруулалтаар шалгарсан хүмүүсийг томилоогүй бол томилох эрх бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэх арга хэмжээг Төрийн албаны тухай хуульд торгууль ногдуулж хариуцлага хүлээлгэхээр заасан⁹ боловч арга хэмжээ авсан ямар нэг баримт алга байна.

Зарим ТАЗСЗ хууль, журам биелүүлэхгүй байна

2.6 ТАЗ-өөс яамдын ТНБД, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга, төрийн захиргааны бусад байгууллагын дарга нарт “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд томилгоо хийх талаар өгөх зөвлөмж”-ийг хүргүүлсэн боловч бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.

2.7 Зарим яам, агентлаг төрийн жинхэнэ албаны удирдах болон анх орох иргэнийг албан тушаалд томилон ажиллуулахдаа сул орон тоог зарлалгүй,¹⁰ ТАЗ-ийн дүгнэлт шийдвэр гаргуулалгүй, сонгон шалгаруулалтад ороогүй хүнийг шууд томилон ажиллуулж байна.



2.8 Ингэхдээ түр хугацаагаар хөдөлмөрийн гэрээ байгуулах буюу эсвэл “Хөлсөөр ажиллуулах гэрээ” байгуулж байжээ. Тухайлбал:

Түршилтын хугацаагаар:

- Сангийн яамны ТНБД-ын 2010 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 166 дугаар тушаалаар Хууль эрх зүйн газарт Х.Энх-Амгалан, Л.Мөнхтуяа, Зээл тусламжийн бодлого, хамтын ажиллаганы газарт Н.Дэлгэрбат, Ё.Амарбат, Төрийн сангийн газарт О.Жавхлан нарыг, 2009 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 311 дугаар тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газрын Мэдээллийн технологийн

⁹ТАТХ-ийн 41.1.1.төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд иргэнийг авч ажиллуулахдаа энэ хуулийн 16.2, 17.1, 17.4-т заасныг зөрчсөн албан тушаалтныг 25000-40000 төгрөгөөр торгох;

¹⁰ ТАТХ-ийн 17.4-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 17.1-д заасан албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих онцлог шаардлагыг харгалзан авах тухай хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад тавина”

хэлтсийн мэргэжилтэн З.Батгэрэл, Зээл тусламжийн бодлого, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн З.Ирмүүн нарыг тус тус туршилтын хугацаагаар томилон ажиллуулж байжээ.

Хөдөлмөрийн гэрээгээр:

- БСШУЯ-ны Гадаад харилцаа хамтын ажиллагаа, ёслол протокол хариуцсан албан тушаалд шалгалтад тэнцээгүй Ж.Төрболд, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ажилтны орон тоонд ТАЗ-өөс нэр дэвшүүлсэн иргэнийг томилоогүй, сонгон шалгаруулалтад тэнцээгүй Д.Жигжид нарыг ажиллуулж байна.
- Мөн яамны Соёл, урлагийн бодлогын газрын даргын сул орон тоог мэдээлэлгүй, сонгон шалгаруулалт явуулалгүй ТНБД-ын 2010 оны 3 дугаар сарын 3-ны 58 дугаар тушаалаар Б.Наранзуныг үүрэг гүйцэтгэгчээр түр томилон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулжээ.
- БОАЖЯ-ны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн сул орон тоог нийтэд зарлан мэдээлэлгүй Ч.Баатар, Д.Амаржаргал, Б.Саранцэцэг нарыг мэргэжилтнээр ажиллуулжээ.

Хөлсөөр ажиллуулах гэрээгээр:

- ЭБЭХЯ-ны ТНБД-ын туслахаар Б.Отгонцэцэг, Уул уурхайн хүнд үйлдвэрийн бодлогын газарт мэргэжилтэн Г.Батцэнгэл нарыг ажиллуулж байна.

2.9 Засгийн газрын тогтоол, ЗТБХБ-ын сайдын тушаал, Нийслэлийн болон Завхан аймгийн Засаг дарга нарын захирамжаар шууд томилгоо хийсэн байна.

Тухайлбал:

- Улаанбаатар хотын Ерөнхий менежер Н.Бат, Үндэсний татварын ерөнхий газрын дарга Ц.Оюунбаатар, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Батмөнх, дэд дарга Д. Мөнхжаргал, Төмөр замын газрын дэд дарга Л.Пүрэвбаатар, Авто тээврийн газрын дэд дарга Н.Пунцаг, Завхан аймгийн ЗДТГ-ын дарга П.Нямжав, Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын дэд дарга Н.Энхтүвшин нарыг сонгон шалгаруулалтагүйгээр томилон ажиллуулж байна.
- ЗГХА Авто тээврийн газар 14 сул орон тоонд сонгон шалгаруулалтад ороогүй хүнийг 2009 оны 10 дугаар сарын 15-ны өдөр тушаал гарган ажиллуулж байна.

2.10 Түүнчлэн ТАЗ-ийн дүгнэлтийг авалгүй холбогдох албан тушаалд томилсон байна.

- ТӨХ Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын даргаар Х.Хэрлэн, Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессийн газрын даргаар Б.Заяабал нарыг ТАЗ-ийн дүгнэлт гаргуулалгүй томилсон нь Удирдах ажилтныг сонгон шалгаруулах журмын 9.в заалтыг¹¹ зөрчсөн байна.

Зарим сонгон шалгаруулалтад өрсөлдөөний зарчим алдагдсан байна

2.11 “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу 2-оос доошгүй хүнийг сонгон шалгаруулалгүй, зарим удирдах албан тушаалд өрсөлдөгчгүй нэр дэвшүүлсэн байна.¹² Тухайлбал:

- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дэд дарга Л.Зориг, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дэд дарга Ц.Доржпалам, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга С.Энхбаатар, Ц.Пүрэвдорж, Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга Д.Гүнбазар, Авто замын газрын дэд дарга Р.Онон, Газрын тосны газрын дэд

¹¹ “Журмын 14-ийн “а”, “б”-д заасны дагуу тухайн орон тоог нөхөх боломжгүй тохиолдолд уг ажлын байранд ажиллах удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах захиалгыг АБТ-ын хамт Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлд бичгээр мэдэгдэнэ”.

¹² Журмын 14.а-д зааснаар “... мэргэшлийн түвшингээр нь 2-оос доошгүй хүнийг сонгон шалгаруулж, Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн албан тушаал дэвшүүлэх замаар уг орон тоог нөхөж болно”.

дарга Ц.Амраа, Эрчим хүчний газрын дэд дарга П.Ганхүү, Эрүүл мэндийн газрын дэд дарга Ц.Хун, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дэд дарга У.Отгонбаяр, Ж.Баярмагнай, Мал эмнэлгийн үржлийн газрын дэд дарга Д.Оргил нарын нэрийг өрсөлдөгчгүй дэвшүүлж дүгнэлт гаргажээ.

2.12 ТАЗ болон аудитын баг хамтарч Төв аймгийн ТАЗСЗ-ийн үйл ажиллагаатай танилцахад дараахь зөрчил илэрлээ. Үүнд:

- Салбар зөвлөлийн дүгнэлт гараагүй байхад ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга С.Цогтбаяр, НХХ-ийн дарга З.Намнансүрэн, ХБХ-ийн дарга Д.Чулуунбат, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт, ХЗХ-ийн дарга М.Мэндсүрэн нарыг ЗДТГ-ын даргын 2009 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 4 дүгээр тушаалаар томилжээ.
- Мөн журмын заалтыг¹³ зөрчиж аймгийн Боловсрол, соёлын газрын дарга Н.Энхтуул, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтсийн дарга Д.Батцэцэг нарыг сонгон шалгаруулалтад хамруулаагүй байна.

2.13 Татварын ерөнхий газрын дэргэдэх ТАЗСЗ-ийн үйл ажиллагаатай танилцахад дараахь зөрчилтэй зүйл ажиглагдсан. Үүнд:

- Татварын ерөнхий хуулийн 41.1, 41.2-т заасныг үндэслэн татварын байгууллагад “хураагч” гэсэн орон тоог 2008 оноос шинээр бий болгож улмаар 2010 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар 102 хүн ажиллуулж байна.
- Засгийн газрын 2007 оны “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 354 дүгээр тогтоолд Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлд заасан “татварын хураагч” гэсэн албан тушаалын ангилал, зэрэглэл байхгүйгээс ТЕГ-аас тухайн ажилтнуудыг албан тушаалын аль ангилал, төрөлд хамруулах нь тодорхойгүй байна. Тус газраас энэ талаар ТАЗ, Сангийн яам, Улсын дээд шүүхэд хандсан боловч шийдвэрлэгдээгүй байна.
- ТЕГ-ын даргаар ажиллаж байсан Л.Зоригийн 2008 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 221 дүгээр тушаалаар Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст 14 хүнийг татвар хураагчаар томилжээ. Татвар хураагчаар томилогдсон хүмүүсээс Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн ажилтан Д.Баярмаа, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн Д.Халиунцэцэг нар тухайн байгууллагад ажилладаггүй, тийм хүн огт байгаагүй байна.
- Мөн өдрийн 222 дугаар тушаалаар нийслэл, дүүргийн татварын хэлтэст татварын улсын байцаагч болон хураагчаар томилогдон ажиллаж байгаа 590 албан хаагчдын нэрсийн жагсаалтыг хавсралтаар батлахдаа Налайх, Багануур дүүргийн татварын хэлтсийн 30 хүнийг баталгаажуулалгүй орхигдуулсан байна. Мөн дээрх 2 тушаал нь үг үсгийн алдаатай, нэр буруу ташаа бичигдсэн, зарим татварын байцаагч, хураагч нарын албан тушаалыг ташаарсан, дутуу дулимаг, бүрэн бус мэдээлэлтэй байна.

Төрийн албаны тухай шинэчилсэн хуульд заасан журам бүрэн батлагдаагүй байна

2.14 Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу УИХ-аас 6, Засгийн газраас 5, ТАЗ-өөс 3, бүгд 14 журам баталж гаргахаас батлагдсан 4, боловсруулалтын шатанд 4, хэлэлцүүлгийн шатанд 6 байна. /Хавсралт 15-д үзүүлэв/

2.15 “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ыг боловсруулж, “Төрийн жинхэнэ албаны удирдах

¹³ /ᠡᠭᠣᠳᠡᠢ 2.10-а “ᠣᠳᠡᠶᠡᠢ ᠠᠶᠠᠠᠢ ᠨᠠᠶᠠᠠᠳ ᠴᠣᠠᠶ᠋ᠭᠡ ᠢᠦ ᠶᠢᠶᠢ ᠠᠳᠣᠳᠢᠠᠢ 9-а ᠴᠠᠠᠨᠢᠠᠠᠨ ᠠᠣᠨᠠᠠ ᠪᠠᠶᠠᠠᠳ ᠠᠶᠠᠠᠢ ᠣᠣᠣᠠᠠᠠ ᠣᠢᠶᠡᠢᠠᠠᠢᠠᠢ ᠠᠶᠡᠶᠡᠣᠢᠠᠢ ᠨᠢᠢᠠᠢ ᠣᠠᠶᠠᠠᠳᠣᠣᠶᠠᠢ”

албан тушаалд тавигдах тусгай шаардлагын төсөл"-ийг шинэчлэн УИХ-д өргөн мэдүүлсэн боловч батлагдаагүй байна.

2.16 “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ыг боловсруулж, Засгийн газарт өргөн мэдүүлсэн ч шийдвэр гараагүй байна.

2.17 “Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах журам” боловсруулах шатанд байна.

Удирдах ажилтны нөөцийг мэдээлэхгүй байна

2.18 Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн иргэдийг ТАЗ-ийн цахим хуудсаар мэдээлдэггүй бөгөөд удирдах албан тушаалд нэр дэвшиж, томилогдсон иргэнийг хэрхэн сонгосон болон нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг нийтэд мэдээлэх ажил хийгдэхгүй байна.¹⁴

2.19 ТАЗ-ийн тогтоолоор мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг онооны дарааллаар жагсаан нөөцөд бүртгэж байгаа ч тухайн ажлын байранд томилогдсон нэр дэвшигчийг бүртгэлээс хасахгүй байна.

Ихэнх гомдол, маргаан ажлаас үндэслэлгүй халагдсан, албан тушаалтны хууль бус ажиллагаатай холбоотой байна

2.20 ТАЗ төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалттай холбоотой гомдол, маргааныг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй. Ирсэн гомдол, маргааныг агуулгаар нь авч үзвэл:

- 2008 онд нийт 102 өргөдөл, гомдол ирснээс ажлаас үндэслэлгүй халагдсан тухай гомдол 49, албан тушаалтны хууль бус шийдвэртэй холбогдсон маргаан 1, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаатай холбоотой 13, ТАЗСЗ-ийн шийдвэрийг үл зөвшөөрсөн тухай 5, албан тушаалын томилгоо хийгдээгүйтэй холбогдсон гомдол 1 иржээ. Нийт ирсэн гомдлын 12 хувь буюу 12 гомдол сонгон шалгаруулалттай холбогдсон байна.
- 2009 онд нийт 171 маргаан хянан шийдвэрлэгдсэнээс ажлаас үндэслэлгүй халагдсантай холбогдсон маргаан 69, албан тушаалтны хууль бус шийдвэртэй холбоотой 11, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаатай холбогдсон гомдол 8, ТАЗСЗ-өөс гаргасан шийдвэрийг үл зөвшөөрсөн гомдол 3, томилгоо хийгдээгүй гомдол 13 бүртгэгджээ. Нийт ирсэн гомдлын 17.5 хувь буюу сонгон шалгаруулалттай холбогдсон 30 гомдлыг журмын дагуу тухай бүр комисс томилон шийдвэрлэж хариуг өгчээ.

ТАЗСЗ-ийн үйл ажиллагааг 2009 оноос эхлэн дүгнэж байна

2.21 2010 оны байдлаар 11 яам, 14 агентлаг, 21 аймаг, нийслэлд ТАЗСЗ ажиллаж байна.

¹⁴ ОБУСТХ-ийн 45.4-е-ий “О”-д өгөгдөх агаарын өрөөнийг агаарын өрөөнийг үндэслэлгүй халагдсан тухай гомдол 49, албан тушаалтны хууль бус шийдвэртэй холбогдсон маргаан 1, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаатай холбоотой 13, ТАЗСЗ-ийн шийдвэрийг үл зөвшөөрсөн тухай 5, албан тушаалын томилгоо хийгдээгүйтэй холбогдсон гомдол 1 иржээ. Нийт ирсэн гомдлын 12 хувь буюу 12 гомдол сонгон шалгаруулалттай холбогдсон байна.

2.22 ТАЗ-ийн даргын 2010 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 17 дугаар тушаалаар ТАЗСЗ-үүдийн 2009 оны тайланд үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулж ТАЗСЗ-ийн үйл ажиллагааг нийт 5 сэдвийн хүрээний 25 арга хэмжээгээр үнэлэх үнэлгээний аргачлал баталсан байна.

2.23 Үнэлгээнд 44 ТАЗСЗ хамрагдсан бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл хамрагдаагүй байна.

2.24 2010 оноос эхлэн ТАЗ-өөс салбар зөвлөлүүдтэй хамтран Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах ажлын үр дүнг шалгах ажлыг улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар зохион байгуулж байна. Дархан-Уул, Төв аймаг, нийслэлийн салбарын энэ талаар хийсэн ажлын тайланг ТАЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн тодорхой үүрэг чиглэл өгч ажиллажээ.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэж дараахь дүгнэлт хийж байна:

1. Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах, мэргэшлийн шалгалтыг зохион байгуулах ажилд ахиц гарч байгаа ч түүнийг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.
2. Төрийн албанд анх орох мэргэшлийн шалгалтыг жилд 1-2 удаа зохион байгуулж байсан нь хүндрэлтэй, гомдол маргаан их гардаг байсан бол 2009 оны сүүлийн хагас жилээс ажлын байрны захиалгыг ирүүлсэн тухай бүр явуулснаар олон түмний хяналтын дор, ил тод, үр дүнтэй зохион байгуулах боломж бүрдсэн байна.
3. ТАЗ төрийн жинхэнэ албаны удирдах зарим албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулахдаа зөвхөн 1 хүний нэрийг өрсөлдөгчгүй дэвшүүлж дүгнэлт гаргасан байна.
4. Зарим яам, агентлаг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын орон тоонд ТАЗ-д мэдэгдэлгүй, олон нийтэд зарлалгүй, ТАЗ-өөс дүгнэлт гаргуулалгүй хүн томилох, эсвэл ТАЗ-ийн шийдвэр, санал дүгнэлтийг үл хэрэгсэн, дур мэдэн томилгоо хийх явдал гарсаар байна.
5. Орон нутагт төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа хангалтгүй хийгдэж байна. Орон нутгийн ТАЗСЗ-ийн дарга нь ЗДТГ-ын дарга байгаа нь зохимжгүй байна.
6. Сонгон шалгаруулах ажиллагаатай холбогдож гарах зардлыг төсөвт тусгадаггүй, хөрөнгийг захиран зарцуулах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс мөнгөн хөрөнгийн орлого, зарлагыг тайлан тэнцэлд тусгаагүй, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.
7. ТАЗ, ҮСХ, СЯ-ны төрийн албан хаагчдын тооны талаар гаргаж буй мэдээллүүдийг уялдуулж байх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн дарга Д.Зүмбэрэллхамд зөвлөж байна:

1. Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах, мэргэшлийн шалгалтыг зохион байгуулах ажлыг боловсронгуй болгох, уг ажилд орчин үеийн технологийн ололтыг нэвтрүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
2. “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу удирдах албан тушаалд 2-оос доошгүй хүнийг сонгон шалгаруулж нэр дэвшүүлж байх,
3. Үүрэг гүйцэтгэгчээр буюу түр томилох, хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулах гэх мэт хуульд заагдаагүй томилгооны хэлбэрийг хэрхэх талаар санал боловсруулж холбогдох байгууллагуудад хандан шийдвэрлүүлэх,
4. Төрийн албаны хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээг зөрчих, ТАЗ-ийн шийдвэр, санал дүгнэлтийг үл хэрэгсэх, дур мэдэн томилгоо хийх, шалтгаангүйгээр ажлаас халах зэрэг зөрчлийг гаргуулахгүй байх талаар ажил олгогч нартай тооцох хариуцлагын боловсронгуй тогтолцоо бий болгох чиглэлээр санал боловсруулж, шийдвэрлүүлэх,
5. Яам, агентлаг, орон нутгийн салбар зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт, эрх, үүргийг оновчтой болгох асуудлыг судалж, шийдвэрлүүлэх,
6. Сонгон шалгаруулах ажилд шаардагдах зардлын эх үүсвэрийг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх санал боловсруулж шийдвэрлүүлэх, хөрөнгийн орлого, зарлагыг нягтлан бодох бүртгэлд хууль тогтоомжийн дагуу тусгаж, тайлагнаж байх,
7. Төрийн албан хаагчдын орон тоог мэдээлэх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран судалж, шийдвэрлэх.

Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Б.БАТБАЯР
ТАНАА

МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

211238 Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж 11,
Утас: 264216, Факс: 264460

2010.11.25. № 934.
танай _____-ны № _____-Т

Аудитын тайланд санал өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хорооны санал, Үндэсний аудитын газрын 2010 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалт, түүний үр дүн"-д танай байгууллагаас хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд сүүлийн жилүүдэд гарч байгаа ажлын нааштай үр дүнг судалгаагаар баримтжуулан тусгаснаас гадна мэдэгдэхүйц ахиц гарч байгаа боловч бүрмөсөн таслан зогсоогдоогүй байгаа зарим зөрчил дутагдлыг зааж дүгнэлт зөвлөмж боловсруулсан байна.

Тайлангийн төсөлд өгөх тодорхой саналгүй бөгөөд зөвлөмжийг цаашдын ажилдаа анхааран ажиллах болно.




Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ


D:/backup/zarim tootuudaas

001335

АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗУРАГЛАЛ



ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛД АНХ ОРОХ ИРГЭНИЙ МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗУРАГЛАЛ



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЯВЦЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛД ХАМААРАХ АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

		Түшмэлийн ангилал зөвхөн АА, ТЗ, ТТ ангилалд хамаарах				Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг харууцах субъект		Мөрдөж буй эрх зүйн акт
Удирдах	Төргүүн түшмэл	АА-1	ТЗ-14	Яамдын ТНБД/11/болон түүнтэй адилтгах бусад албан тушаалтан /8/	ТТ-18	Төрийн албаны зөвлөлөөс гадна ТТ буюу Төрийн тусгай албан тушаалыг салбарын хуулиар зохицуулагдаг бөгөөд Төрийн албаны зөвлөлөөс зөвхөн шалгалт авах журмыг нь баталж өгч байна.	Төрийн албаны тухай хуулийн 35.1.6, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45, УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"	
		АА-2	ТЗ-13	Засгийн газраас байгуулсан агентлагийн дарга, түүнтэй адилтгах албан тушаалтан /42/	ТТ-17			
		АА-3		Үндэсний статистикийн хорооны газрын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтан /10/				
		АА-4	ТЗ-12	Яамдын газрын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтан /60/	ТТ-16			
	Эрхэлсэн түшмэл		ТЗ-11	Аймгийн ЗДТГ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга /44/	ТТ-15			
			ТЗ-10	ТАЗСЗ-гүй, Засгийн газрын агентлагийн газрын дарга, Засгийн газраас байгуулсан Төрийн захиргааны байгууллагын дэд дарга /8/	ТТ-14			
			ТЗ-9	Засгийн газрын агентлагийн хэлтсийн дарга, Чөлөөт бүсийн ЗАА-ын хэлтсийн дарга /6/				
	Ахлах түшмэл /зарим албан газарт удирдах Албан тушаалд Хамаарч байна/		ТЗ-8	Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын нэгжийн дарга /3/				
		Дэс түшмэл	ТЗ-7	Яам, агентлаг зэрэг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын мэргэжилтнүүд энэ ангилалд хамаарч байна.	ТТ-9			ТАЗСЗ-өөс сул орон тооны захиалга ирүүлнэ. Салбар зөвлөлгүй бол ТАЗ-д ирүүлнэ. ТАЗ-өөс нөөцөөс нөхөх зарлал болон сонгон шалгаруулалтыг зарлана. Төрийн төв байгууллагуудын сонгон шалгаруулалтыг зөвлөл бие даан явуулна. Аймаг, нийслэл дэх сонгон шалгаруулалтыг ТАЗСЗ-өөс байгуулагдсан салбар комисс зохион байгуулж, ерөнхий удирдамжаар ТАЗ-өөс байгуулагдсан Төв комисс хангана.
	ТЗ-6			ТТ-8				
ТЗ-5			ТТ-7					
ТЗ-4			ТТ-6					
ТЗ-3			ТТ-5					
ТЗ-2			ТТ-4					
			ТТ-3					
Гүйцэтгэх	Туслах түшмэл			ТТ-2, ТТ-1				
		ТЗ-1						

Хавсралт №3.1

Хавсралт №3.1

2. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЯВЦЫН ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛД ХАМААРАХ АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

Түшмэлийн ангилал зөвхөн АА, ТЗ, ТТ ангилалууд хамаарах		Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг хариуцах субъект	Мөрдөж буй эрх зүйн акт
Удирдах	Эрхэлсэн түшмэл	ТЗ-11 Яамны газрын орлогч дарга	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45 дугаар зүйл, УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 13 дугаар тогтоол
		ТЗ-10 Яамны хэлтсийн дарга, Засгийн газрын агентлагийн газрын дарга	
Гүйцэтгэх	Ахлах түшмэл /зарим албан газарт удирдах албан тушаалд хамаарч байна/	ТЗ-9 Яамны тасгийн дарга, Засгийн газрын агентлагийн хэлтсийн дарга	Төрийн албаны зөвлөлөл салбар зөвлөл
		ТЗ-8 Нийслэлийн ЗДТГ-ын Тасгийн дарга, Нийслэлийн Засаг даргын эрхлэх хүрээний асуудлын нутгийн захиргааны байгууллагын нэгжийн дарга, дүүргийн ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, дүүргийн ЗДТГ-ын дарга, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга	
Туслах	Ахлах түшмэл /зарим албан газарт удирдах албан тушаалд хамаарч байна/	ТЗ-7 Аймгийн ЗДТГ-ын Тасгийн дарга, Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын нэгжийн дарга, дүүргийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс /алба/-ийн дарга, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, сумын Засаг даргын Тамгын газрын дарга, улсын зэрэглэлтэй хотын захирагчийн ажлын албаны дарга	

Хавсралт №4

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧДЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААРХИ САНАЛ АСУУЛГА

Д.д	Санал, асуултын товч агуулга	Хариултын				Дүн
		хувилбар	Тоо			
			Яам	Агентлаг	Бусад	
1	Та ТАЗ-ийн хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааны одоогийн бүтэц, зохион байгуулалт оновчтой гэж үздэг үү?	Тийм	18	10	13	41
		Үгүй	19	3	1	23
		Мэдэхгүй	8	2	2	12
2	ТАЗ-өөс Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг зөв зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллаж байна уу?	Тийм	15	5	13	33
		Үгүй	20	4	1	25
		Мэдэхгүй	10	6	2	18
3	Та ТАЗ, төрийн албаны салбар зөвлөлөөс явуулж буй сонгон шалгаруулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх хяналтын тогтолцоо бүрдсэн гэж үздэг үү?	Тийм	12	3	9	24
		Зарим талаар	28	10	7	45
		Үгүй	5	2	0	7
4	Төрийн жинхэнэ албан хаагчдын сонгон шалгаруулалтыг одоогийн энэхүү тогтолцоогоор цаашид явуулж байх нь зүйтэй гэж үздэг үү?	Тийм	13	6	11	30
		Шаардлагагүй	6		1	7
		Өөрчлөх	26	9	4	39
5	Таны бодлоор төрийн жинхэнэ албан хаагчдын сонгон шалгаруулалтыг хуулийн ямар этгээд явуулбал оновчтой гэж үзэж байна вэ?	Одоогийн	15	8	13	36
		ТЕЗ буюу АО	25	4	2	31
		Мэдэхгүй	5	3	1	9
6	Сонгон шалгаруулалтаар шалгарсан болон ТАЗ-өөс дүгнэлт гаргасан этгээд зарлагдсан сул орон тоонд ажиллаж чадаж байна уу?	Тийм	11	3	7	21
		Зарим талаар	26	8	7	41
		Үгүй	8	4	2	14
7	Сонгон шалгаруулалтаар шалгарсан этгээд тухайн ажлын байрны тодорхойлолтод тусгасан шаардлагуудыг хангаж чаддаг уу?	Бүрэн	6	4	1	11
		Зарим тохиолдолд	34	9	14	57
		Огт үгүй	5	2	1	8
8	Танай байгууллагад ТАЗ-ийн сонгон шалгаруулалтанд ороогүй хүнийг удирдах албан тушаалд томилон ажиллуулж байна уу?	Тийм	2		1	3
		Зарим тохиолдолд	12	3	1	16
		Үгүй	31	12	14	57
9	Танай байгууллагад Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтгүйгээр ажилтан ажиллуулдаг уу?	Тийм	5		1	6
		Зарим тохиолдолд	22	6	3	31
		Үгүй	18	9	12	39
10	Та төрийн жинхэнэ албан тушаалын сонгон шалгаруулалтыг явуулж албан тушаалд томилж байгаагаар төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан гэж үздэг үү?	Тийм	10	6	9	25
		Зарим талаар	25	6	4	35
		Үгүй	10	3	3	16
11	Та төрийн албаны зөвлөлийн өнөөгийн үйл ажиллагааг хэрхэн үнэлж байна вэ?	Сайн	13	3	11	27
		Дунд	30	11	4	45
		Мэдэхгүй	2	1	1	4
12	Таны бодлоор Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт ямар түвшинд байна	Хэрэгжиж байна	17	6	11	34
		Хангалтгүй	27	9	3	39

вэ?	Хэрэгжихгүй байна	2	1	3
-----	-------------------	---	---	---

᠐᠗ᠠᠶᠢᠳᠠᠭᠦ 15

ӨӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ДАГУУ ГАРГАХ ЭРХ ЗҮЙН АКТУУДЫН БАТЛАГДСАН БАЙДАЛ

Ä.ä	Журам батлах байгууллага	Хэлэлцүүлэгт /хуулийн заалт, огноо/	Батлагдсан журам /хуулийн заалт, огноо/	Боловсруулах шатанд
1	УИХ-ын тогтоолоор батлуулах	<p>1. “ТБУС 0᠐-᠙᠙1 45.1-д заасан төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг тогтоох тухай” <u>ТАТХ-ийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг</u> ТАЗ-ийн 2009.12.11-ний 1048 тоот бичиг</p> <p>2. “ТАЗ-ийн орон тооны салбар зөвлөл болон ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай” <u>ТАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 13 дэх хэсэг</u> ТАЗ-ийн 2009.12.30-ний 1159 тоот бичиг</p>	<p>1. “УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, УДШ, УЕПГ, ХЭҮК, ТАЗ,ҮАБЗ,СӨХ, СЗХ, ҮСХ, ШЕЗ-ийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” <u>ТАТХ-ийн 7 дугаар зүйлийн 9 дэх хэсэг</u> УИХ-ын 2009.1.16-ны 06 дугаар тогтоол</p> <p>2. “ТАЗ-ийн үйл ажиллагааны дүрмийг шинэчлэн тогтоох тухай” <u>ТАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг</u> УИХ-ын 2009.12-ний 87 дугаар тогтоол</p>	<p>1. “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй Адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” <u>ТАТХ-ийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг</u></p> <p>2. “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журмыг шинэчлэн тогтоох тухай” <u>ТАТХ-ийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дугаар заалт</u></p>
2	ЗГ-ын тогтоолоор батлуулах	<p>1. “Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” <u>ТАТХ-ийн 7 дугаар зүйлийн 10 дахь хэсэг</u> ТАЗ-ийн 2009.9.17-ны 726 тоот албан бичиг</p> <p>2. “Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” <u>ТАТХ-ийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг</u> ТАЗ-ийн 2010.9.17-ны 726 тоот албан бичиг</p> <p>3. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм батлах тухай” <u>ТАТХ-ийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг</u> 2009.6.15-ны 455, 9.17-ны 726 тоот бичиг</p> <p>4. “Төрийн захиргааны албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмыг шинэчлэн батлах тухай “ <u>ТАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг</u> 2009.6.15-ны 455, 9.17-ны 726 тоот бичиг</p>	<p>1. “Төрийн жинхэнэ албан хаагчид 36 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам батлах тухай “ <u>ТАТХ-ийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг</u> ЗГ-ын 2009.6.3-ны 164 дүгээр тогтоол</p>	
3	ТАЗ-ийн тогтоолоор батлуулах		<p>1. “Төрийн албаны мэргэшлийн шалгалт авах болзол, журмыг шинэчлэн батлах тухай “ <u>ТАТХ-ийн 17 дугаар зүйлийн 8 дахь хэсэг</u> ТАЗ-ийн 2009.4.6-ны 63 дугаар тогтоол</p>	<p>1. “Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажлуулах журам батлах тухай “ <u>ТАТХ-ийн 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэг</u></p> <p>2. “Төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлага батлах тухай “ <u>ТАТХ-ийн</u></p>

				<u>33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг</u>
--	--	--	--	---------------------------------------



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2010 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалт, түүний үр дүнд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хороо, Төрийн албаны зөвлөлд хүргүүлсүгэй.

Гурав.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2011 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн дарга Д.Зүмбэрэллхамд зөвлөсүгэй.

Дөрөв.Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070257

tushaal